

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна. Үүнд:

1. ТЭЗҮ, зураг, төсөв хийгдээгүй төсөл, арга хэмжээг аймгийн ИТХ-ын хуралдаанаар баталж, дараа нь нөхөж хийсэн байна. Уг зөрчлийг арилгах зөвлөмжийг өмнөх аудитаар өгсөн ч биелүүлээгүй байна.
2. Төсөл, арга хэмжээний зураг, төсөв хийх ажил, тендерийг цахимаар зарласантай холбогдуулан компаниуд РКI код авах явц удааширсан, шаардлага хангахгүй тендерийн баримт бичиг ирсэнээс тендер хүчингүй болж дахин зарлагдсан зэргээс худалдан авах ажиллагаанд хугацаа их зарцуулсан байна.
3. Төсөл, арга хэмжээний нэр сольсон, батлагдсан төсөвт өртгөөс хэтрүүлэн тендер зарласан тохиолдол гарсан байна.
4. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг шалгаруулахад хугацаа их алдсаны улмаас гүйцэтгэлийн байдал цаг хугацааны хувьд оройтсон байна. Нийт төсөл, арга хэмжээний санхүүжилтын 42.2 хувийг Сангийн яам зарцуулалтын эрх нээгээгүйгээс олгож чадаагүй байна.
5. Төмөрбулаг сумын халуун усны бариггын ашиглалтын үед гарсан хүндрэлийг эс тооцвол хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй болсон байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурьдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аймгийн ИТХ-ын дарга Т.Болдбаатар-т:

1. ТЭЗҮ, зураг, төсөв хийгдээгүй төсөл, арга хэмжээг аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцэхгүй, батлахгүй байх.
2. АИТХурлын төлөөлөгчдөд Төсвийн тухай хууль, орон нутгийн төсөв батлах чиглэлээр сургалт хийж хууль эрх зүйн дагуу санал гаргаж батлуулж байх.

Аймгийн Засаг дарга А.Эрдэнэбаатар-т:

1. ТЭЗҮ, зураг, төсөв хийгдсэн төсөл, арга хэмжээг аймгийн ИТХ-д өргөн мэдүүлж батлуулж байх.
2. Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 заалтыг зөрчин ТЭЗҮ, зураг төсөв нь батлагдаагүй төсөл арга, хэмжээг төлөвлөсөн холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцон ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх.
3. Өмнөх хөрөнгө оруулалтын аудит болон сүүлийн жилүүдэд баригдсан барилгад хийгдсэн шалгалтаар өгсөн дүгнэлт, зөвлөмж, албан шаардлагуудыг анхааралдаа авч хэрэгжилтийг эрчимжүүлэх, үр дүнг тооцох.
4. Магадлашгүй ажлын зардлыг ТХОСЖ-ын 3.25-д заасны дагуу актаар тогтоон олгож байх.

Аймгийн ЗДТГ-ын ХААА-ны дарга Б.Болд-д:

1. Худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулахад анхаарч, шинээр үйл ажиллагаандаа нэвтрүүлж буй зүйлийг оролцогч талуудад сурталчилах.
2. ТХОСЖ-ын 3.25 дахь заалтыг мөрдөж ажиллах.